



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/276

Номгон

Г Малын хагас жилийн түүвэр судалгаа Г
явуулах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 1.1, “Статистикийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 1.в, “Малын индексжүүлсэн даатгалын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах нийтлэг журмын 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2023 оны хагас жилийн Малын түүвэр судалгааг 2023 оны 05 дугаар сарын 30-наас 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулан явуулсугай.

2. Малын түүвэр судалгааны ажлыг зохион байгуулан явуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналтын тооллогоор сумдад ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Малын түүвэр судалгааны ажлын бэлтгэлийг сайтар хангуулан зохих журмын дагуу, ямар нэгэн зөрчил гаргахгүйгээр зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, хяналт шалгалтын ажлыг чанартай гүйцэтгэн, түүвэр судалгаанд сонгогдсон өрх нэг бүрээр баг, сумын түвшинд цахим програмын дагуу шивж оруулан нэгтгэлийг аймгийн Статистикийн хэлтэст 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн дотор ирүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Малын түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн мэдээлэлд тулгуурлан сумын түвшний нэгтгэл гарч, түүнд үндэслэн даатгалын нөхөн төлбөр олгодог тул мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг хангаж, мэдээллийг шивэх явцад гарч болзошгүй алдаа, нөхөн төлбөр олгох явцад гарах маргаан зэргээс урьдчилан сэргийлж, тооллогын ажилд хариуцлагатай хандахыг сумдын холбогдох албан тушаалтнуудад даалгасугай.

5. Малын түүвэр судалгааны ажилд зарцуулахаар 2023 оны төсөвт тусгагдсан 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.


642319084

2.

6. Малын түүвэр судалгааны ажлыг аргачлал, маягт, заавраар бүрэн хангаж ажиллахыг аймгийн Статистикийн хэлтэс (Г.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

7. Малын түүвэр судалгааны ажлыг сумдад зохион байгуулан явуулж дүн нэгтгэлийг гаргаж Үндэсний Статистикийн Хороонд мэдээлэхийг аймгийн комисс (Б.Батсуурь)-т даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 088-ны 05 дугаар
сарын 25-ны өдрийн 1676 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга

Б.Батсуурь Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд

Г. Ганчимэг Статистикийн хэлтсийн дарга

Ч. Эрдэнэбат Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Г. Энхбаяр Баянхонгор сумын Засаг дарга

С. Энхтөр Баацагаан сумын Засаг дарга

Д. Пүрэвсүрэн Баянбулаг сумын Засаг дарга

Б. Бат-Амгалан Баянговь сумын Засаг дарга

О. Мөнхбат Баянлиг сумын Засаг дарга

Ж. Хатанбаатар Баян-Овоо сумын Засаг дарга

Б. Идэрмөнх Баян-Өндөр сумын Засаг дарга

Н. Гансүх Баянцагаан сумын Засаг дарга

Л. Ганаа Богд сумын Засаг дарга

М. Баярсайхан Бөмбөгөр сумын Засаг дарга

Д. Лхагвадорж Бууцагаан сумын Засаг дарга

Г. Доржбат Галуут сумын Засаг дарга

Б. Гантулга Гурванбулаг сумын Засаг дарга

Д. Мөнхжаргал Жаргалант сумын Засаг дарга

Р. Батжаргал Жинст сумын Засаг дарга

Д. Гантуул Заг сумын Засаг даргын орлогч

Т. Эрдэнэбат Өлзийт сумын Засаг дарга


С. Сумъяабазар Хүрээмарал сумын Засаг дарга

Б. Батэрдэнэ Шинэжинст сумын Засаг дарга

Д. Цэвэгдорж Эрдэнэцогт сумын Засаг дарга

_____оОо_____

Аймгийн Засаг дарга 2013 оны 05 дугаар
сарын 05 ны өдрийн 1076 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



**МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ХЯНАЛТААР
СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ**

- Б. Батсуурь Аймгийн Засаг даргын орлогч

Баацагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал,
Баянбулаг
- Г. Ганчимэг Статистикийн хэлтсийн дарга

Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг, Баян-Овоо,
Өлзийт, Эрдэнэцогт
- Ч. Эрдэнэбат Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Жинст, Богд, Баянлиг, Баянговь Баянцагаан, Баян-Өндөр
Шинэжинст

_____оОо_____